



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2024 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А - 234

Улаанбаатар хот

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дахь заалт, Валютын зохицуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 674 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Дотоодын банкнаас Монголбанканд гадаад валютын хадгаламж байршуулах журам” (цаашид “Журам” гэх)-д дор дурдсан агуулгатай 3.1.4 дэх заалт нэмсүгэй.

“3.1.4 3.1.1-3.1.2-т заасан системд саатал гарсан тохиолдолд энэ журмын нэгдүгээр хавсралтын дагуу хэвлэмэл байдлаар 3 хувь ирүүлэх.”

2. “Дотоодын банкнаас Монголбанканд гадаад валютын хадгаламж байршуулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтын “хэлцлийг” гэсний ард “, эсхүл Блүмберг системд цахимаар баталгаажуулсан хэлцлийг” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтын “биелүүлэхээс” гэсний ард “татгалзах,” гэж тус тус нэмсүгэй.

3. “Дотоодын банкнаас Монголбанканд гадаад валютын хадгаламж байршуулах журам”-ын 2.1.2 дахь заалт, 3.1.1 дэх заалт, 3.1.2 дахь заалт, 3.1.3 дахь заалт, 3.2 дахь хэсэг, 3.4 дэх хэсэг, 6.1 дэх хэсгийг тус тус дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1. “2.1.2 “Цахим арилжааны систем” гэж дотоодын банк хоорондын арилжааг цахим системээр хийхэд зориулагдсан арилжааны системүүдийн ерөнхий нэршлийг;”
2. “3.1.1 Цахим арилжааны системээр;”
3. “3.1.2 Блүмберг системийн өөрийн баталгаажсан хаягаар;”
4. “3.1.3 Зөвшөөрөгдсөн цахим шуудангийн хаягаар;”
5. “3.2 Мөнгөний захын үйл ажиллагаа хариуцсан газар нь гадаад валютын хадгаламж байршуулах саналыг судалж, хадгаламжийн хүүгийн түвшин, хэмжээг тухайн банканд хүргүүлэх ба харилцан зөвшөөрч биелсэн хэлцлийг баталгаажуулж, өөрийн мэдээллийн санд хадгална.”
6. “3.4 Банк энэ журмын 3.1.1-т зааснаас бусад хэлбэрээр хадгаламж байршуулах болон сунгах саналаа ирүүлсэн тохиолдолд Мөнгөний захын үйл ажиллагаа хариуцсан газар нь банкны саналыг цахим арилжааны системд оруулж, хадгаламжийн хэлцлийг Санхүү бүртгэл хариуцсан газарт тухайн ажлын өдрийн 16:00 цагаас өмнө хүргүүлнэ.”
7. “6.1 Банк нь валютын эх үүсвэрийг хожимдуулсан тохиолдолд хадгаламжийн хэлцлийн мөнгөн дүнд харгалзах хугацааны ОУТБ-ны хүүтэй тэнцэх хүүгийн торгууль ногдуулна.”

1524011820


4. “Дотоодын банкнаас Монголбанканд гадаад валютын хадгаламж байршуулах журам”-ын дараах хэсэг, заалтуудад дор дурдсан агуулга бүхий өөрчлөлтийг оруулсугай.

1. Журмын 1.4 дэх хэсгийн “...Валют, эдийн засгийн газар (цаашид ВЭЗГ гэх)...”; 3.1;5.1.1;5.2.2 дахь хэсгүүд дэх “ВЭЗГ” гэснийг “Мөнгөний захын үйл ажиллагаа хариуцсан газар” гэж өөрчлөх;
2. Журмын 2.1.3 дахь заалтын “...Блүмбергийн MGFХ цахим арилжааны цонхоор...” гэснийг “...Блүмберг системээр...” гэж өөрчлөх;
3. Журмын 3.3 дахь хэсгийн “...3.3-т...” гэснийг “...3.2-т...” гэж, “...хийх...” гэснийг “...байгуулах...” гэж тус тус өөрчлөх;
4. Журмын 3.5 дэх хэсгийн “ТТБГ...” гэснийг “Санхүү бүртгэл хариуцсан газар...” гэж өөрчлөх.

5. Энэ тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Санхүүгийн зах зээлийн газар (А.Энхжин), Санхүү бүртгэлийн газар (Ц.Гарьд)-т тус тус үүрэг болгосугай.

6. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (А.Шижирмаа)-т даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Б.ЛХАГВАСҮРЭН